

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН
ШАЛГАХ АЛБАНЫ 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Төлөвлөгөөг хянасан:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД

.....
(албан тушаал)

Тэмдэг

.....
(гарын үсэг)



Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА

.....
(албан тушаал)



Тэмдэг

.....
Ж.ЦОЛМОН /

.....
(гарын үсэг)

.....
(огноо)

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2021.06

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол тайлбар/
Стратеги төлөвлөгөөний зорилто 1. Хуулиар олгосон чиг үүрэг							
1	Осол, зөрчлийн мэдээллийг авах ангилан бүртгэх						
1.1	Иргэний агаарын хөлөг тохиолдсон нислэгийн зөрчлийг бүртгэх, ангилах, мэдээллийн санг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны зардал	ИНД-12 "Осол, зөрчлийг мэдээллэх"	2020 онд нийт 30 тохиолдол ангилан бүртгэгдсэн. 2014-2020 оны бүртгэлд дүн шинжилгээ хийгдсэн байгаа.	Тайлангийн хугацааны мэдээллийг бүрэн авч, бүртгэн санг нэмэгдүүлсэн байна.	I-IV улирал	ИНЕГ-ын ЭХАТ-с нислэгийн саатал, зөрчил, дутагдлын 68 тохиолдлын мэдээ, МИАТ ХК-с 3 мэдээ, Аэромонголиа ХХК-с 3 мэдээ ирсэн. 2021 оны эхний хагас жилд нийт 8 зөрчил бүртгэгдсэн байна. Үүнээс: 1. Нислэгийн ашиглалтын заавар зөрчигдсөн – 3 2. Нислэгт бэлэн агаарын хөлөг техникийн бусад шалтгаантай – 1 3. Агаарын хөлөг шувуутай мөргөлдсөн тохиолдол – 3 4. 2-р тойрог нислэгт гарсан тохиолдол – 1 байна. 2020-2021 оны осол, зөрчлийн бүртгэлийн мэдээнд дүн шинжилгээ, ангилал хийж 2021.04.30-ны байдлаар гарган танилцуулга материалыг сайдын зөвлөлийн хуралд танилцуулахаар 2021.05.03-нд 67/21 тоот албан бичгээр хүргүүлсэн.
							100%